

II НИЙГМИЙН ФИЛОСОФИ

Соёмбо тэмдгийн шинжлэх ухааны

утга учир

Н.Хавх

МУИС. Нийгмийн шинжлэх ухааны сургууль

Түлхүүр үг: Пирамидын хууль, кубын хууль, Арга, билгийн тэмдэг, Арга, билгийн квадрат, Инь, Ян, Дээд нэгдэл

Занабазар Өндөр Гэгээний бүтээсэн соёмбо үсэг нь зөвхөн авиа тэмдэглэсэн авиа бичиг төдийгүй ертөнцийн тогтолцооны оршин тогтнох, өөрчлөгдөн хувирах түгээмэл зүй тогтлыг давхар тэмдэглэсэн үсэг хэмээх бодолтой, яриа хөөрөөтэй хүн мэр сэр байдаг юм билээ. Ямар ч байсан соёмбо үсэгт орчин цагийн астрономын шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг өдий төдий тэмдгүүд байдаг гэсэн. Миний бие соёмбо үсгийн талаар мэдлэггүй, бараг төсөөлөлгүй нэгэн болохоор энэ бүхнийг эс өгүүлэн монголчууд олон зуун жилийн турш үндэстэний тусгаар тогтнолын бэлгэдэл болгож авч хэрэглэсээр ирсэн соёмбо тэмдгийн шинжлэх ухааны агуулгын тухай л чадан ядан өгүүлэхийг оролдов.

Евклидийн геометр хийгээд соёмбо тэмдэг МЭӨ ойролцоогоор III зууны үед эртний Грекийн Александрын хотод амьдарч байсан гэж үздэг математикч Евклид орчин үеийн онолын математикийн үндэс суурийг тавьсан гавъяатай хүн аж. Тэрээр “Эш” (начало) хэмээх бүтээлдээ онолын математикийн үндэс болох геометрийн ухаанаа тайлбарласан байдаг аж. Хавтгайн геометрийн үүх түүхийг сонирхоогүй, онолын математикийн уг сурвалжийн талаар төсөөлөлгүй явж ирсэн бидний дотор арван жилийн сургуульд л үздэг байсан, сайндаа инженер хүнд тооцооны зураг зурахад хэрэг болдог төдийхөн зүйл хэмээх бодолтой хүмүүс мэр сэр байдгийг үгүйсгэх аргагүй. Гэтэл Евклидийн бүтээсэн геометрийн дүрсүүд нь ертөнцийн тогтолцооны түгээмэл зүй тогтлын төгс төгөлдөр загвар, модель сонгодогийн дээд сонгодог ухаан аж. Орчин үеийн бүх шинжлэх ухаан улмаар эдийн засаг,

социологи зэрэг нийгмийн өөр бусад шинжлэх ухаан математчилагдсаар байгаа нь цаанаа шинжлэх ухаан бүрийн судлах зүйлийн гүнд ертөнцийн оршин тогтнох түгээмэл зүй тогтол байдгийн, евклидийн геометр, түүнээс салбарлан бий болсон математик нь тэрхүү түгээмэл зүй тогтлын загвар модель гэдгийн тод томруун илрэл байхаар төсөөлөгдөнө. Соёмбо тэмдэг нь евклидийн геометрийн сонгодог дүрсүүдээс голлон бүтнэ. Үүнд:

: Муруйгаар голоороо тэгш хэмээр хуваагдсан тойрог буюу арга, билиг; түүнийг соёмбо үсгийн махбодид эвим гэдэг юм байна.

: 90° -ийн өнцгөөрөө доошоо, гипотенуз талаараа дээшээ харсан хоёр гурвалжин; түүнийг соёмбо үсгийн махбодид чойжүн гэдэг юм байна.

: Арга, билгийн тэмдгийн дугуйн дээр, доор нь байрлах зураасан хэлбэрт дөрвөн өнцөг; түүнийг соёмбо үсгийн махбодид сум гэдэг юм

: байна.

Зуйван тойрог, түүнийг соёмбо үсгийн махбодид нар гэдэг аж.

: Тойргийнхоо талбайн ойролцоогоор 25%-тай тэнцэх хэмжээтэй хавирган саран хэлбэрийн хагас тойрог; түүнийг соёмбо үсгийн махбодид сар хэмээдэг аж.

: Гал.

II: Дээрх бүх тэмдгийн баруун, зүүн талд босоогоор байрлах тэгш өнцөгт дөрвөлжин; түүнийг соёмбо үсгийн махбодид хос шад гэдэг юм байна. Соёмбо үсгийн учир утга нь геометрийн дүрсдээн байгаа болов у гэсэн санааг академич Ц.Дамдинсүрэн гуай гарган тавьжээ гэж болохоор юм. Тэрээр 1947 онд бичиж нийтлүүлсэн "соёмбо үсэг" гэдэг өгүүллэгдээн "Тэнгэр, дэлхий, амьтан гурвын хооронд гурвалжин дүрс бий. Бодвоос Энэтхэгийн Ланз бичгийн үсэг бүр нь ийм дүрс хадсан гурвалжин тэргүүнтэй тул түүнийг дууриалгасан тэмдэг байж болно. Соёмбо үсэгт дөрвөлжин хэдэн зурлага бий. Энэ нь уг үсгийн байдлыг тэгш, гоёмсог болгохоор хийсэн зураг байж болгохоор хийсэн


зураг байж болно. Гурвалжин, дөрвөлжин, дүгрэг (хоёр загас) гурван дүрс бол хэмжих ухааны үндсэн дүрс болохыг тэмдэглэлтэй”¹ гэжээ.

1947 онд бичсэн өгүүлэлдээ, Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн гуай нар соёмбын гол дахь муруй шугамаар тэнцүүхэн хуваагдсан тойргийг **хоёр загас** гэж нэрлэсэн байдаг. “Соёмбын голд нь бие биеэ дагаж эргэсэн хоёр загасны дүрс бий нь эртний монголчууд нүд аньдаггүй амьтан хэмээн маш сонор соргогыг дүрслэхүй дор хэрэглэдэг. Үүнд хоёр загасыг зурсан арга, билиг буюу эр, эм хэмээсэн утгатай нь улсынхаа төлөө дээр дор, эр эмгүй цөм нэгэн сэтгэлээр арга, билиг хослож дайсны эсрэг нүд цавчилгүй сэрэмжилж бай хэмээсэн санаа” гэж Б.Ринчен гуай “Соёмбо тэмдэг бол Монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын алдарт сайхан бэлгэ тэмдэг мөн”² хэмээх өгүүлэлдээ тэмдэглэсэн байна. Их эрдэмтэн дээрх өгүүлэлээ тэр үеийн нам, төрийн удирдлагад өргөн барьсан түүхтэй юм байна. Энэ тухай ам дамжсан яриа ч байдаг. Соёмбо үсгийг төрийн бэлгэдэл болгох тухай асуудал тавигдаж Б.Ринчен гуайгаас, “Та л нам төрийн удирдлагад зөв ойлгуулж өгөөч; эс тэгвээс дарга нар бурхны шашны гарвал үүсэлтэй энэ соёмбо үсгийг төрийн бэлгэдэл болгохыг яавч зөвшөөрөхгүй” хэмээн гуйсан; тэгэхэд Б.Ринчен гуай: “Наад зах нь л гэхэд соёмбын голд нь байдаг энэ дүгрэг чинь тусгаар тогтнолын бат бэхийг бэлгэдсэн эвт хоёр загас, нүд нь энэ байна, сүүл нь энэ байна” гэх мэтээр тайлбарлаж соёмбо үсгийг монголынхоо төрийн далбаан дээр авч үлдээж чадсан тухай ярьсаар ирсэн. “Шашин бол хар тамхи” хэмээх үзэл суртал хатуу чанга байсан тэр үед соёмбын утга, агуулгат үүнээс өөр тайлбар хийх бололцоогүй байсан нь ойлгомжтой.

Пирамидын хууль хийгээд арга, билиг Физикчид, математикчид ертөнц пирамид хэмээх түгээмэл хуультай байдаг тухай ярьдаг, бичдэг. Үнэхээр чиг ертөнцийн үзэгдэл юмс тэр чигээрээ геометрийн пирамид хэмээх дүрсээр загварчлагдсан түгээмэл хуулиар оршин тогтнож, өөрчлөгдөн хувирч байдаг байна. Тэнд зөрчлийг бий болгогч эсрэг, тэсрэг талууд бий; тэр талууд нь

¹ Ц.Дамдинсүрэн. “Соёмбо үсэг” Соёмбын нууц ба синергетик, УБ, 2005. 292 дахь тал.
² Б.Ринчен. “Соёмбо тэмдэг бол Монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын алдарт сайхан бэлгэ тэмдэг мөн”, Соёмбын нууц ба синергетик, УБ, 2005. 289 дахь тал.

харилцан бие биеэ үгүйсгэхийн хирээр нөхцөлдүүлнэ; тэнд эсрэг талуудын шинж нэг нь нөгөөдөө шингэн, өөр хоорондоо шүтэн барилдах зүй тогтол, хөгжил хөдөлгөөний улиран дэвших зам бий. Хөгжлийн өгсөх, хийгээд уруудах; мандах хийгээд буурах; энэ бүхний дагуу зөв сэтгэн бодох зүй тогтол ч бас тэнд бий. (Зураг№1)



Зураг№1 (пирамид)

1. Ертөнцийн бүх үзэгдэл, юмс пирамидын тогтолцоотой; хүний хувьд пирамидын орой буюу Е нь түүний уураг тархи, оюун ухаан, пирамид бүхэлдээ хүний бие, пирамидын суурь нь хөл гар, захын мэдрэлийн эс эрхтэн; нарны системийн гаргийн хувьд пирамидын орой нь нар, суурь нь нарны системийн од гараг; атомын хувьд пирамидын орой нь атомын (+) цэнэгтэй цөм, их бие нь (-) тэмдэгтэй электронууд, улсын хувьд

пирамидын орой нь төрийн тэргүүн, төр засаг, их бие нь зэрэг дэвээрээ байрласан олон түмэн; гэр бүлийн хувьд бол пирамидын орой нь өрхийн тэргүүн, нөхөр; их бие нь эхнэр үр хүүхэд гэр бүлийн бусад гишүүд; уралдааны моридын хувьд пирамидын орой нь наадмын түрүү, айрагдсан морь; их бие нь бусад морьд, суурь нь баян ходоод, гэх мэт.

2. Диагналаар хуваахад үүссэн EADC тал пирамид нь зөрчлийг бий болгогч билгийн, түүний эсрэг EACB тал нь зөрчлийг бий болгогч аргын тал. Билиг гэдэг нь тухайн тогтолцоогоо тогтвортой тэнцвэртэй байлгах, бүрэлдэхүүн хэсгүүдийг өөр хооронд нь шүтэн барилдуулах, хөгжил хөдөлгөөний зүг чиг заах үүрэгтэй; арга гэдэг нь үүний яг эсрэг; тухайн тогтолцоогоо өөрчлөн хувиргах, бүрэлдэхүүн хэсгүүдийг өөр хооронд нь өрсөлдүүлэх, тэмцэлдүүлэх хөгжил хөдөлгөөний эрч хүч болох үүрэгтэй тэр тал. Эхнийх нь өрний гүн ухаанд нэгдлийн, хоёр дахь нь тэмцлийн тал гэнэ. Хятадын гүн ухаанд эхнийхийг нь "Инь", хоёрдахийг нь "Ян" гэнэ. Дээрх тал пирамидууд нь үзэгдэл юмны хөгжлийн уг сурвалж болох зөрчлийг бий


болгодог бөгөөд сонгодог гүн ухааны түвшинд яригддаг нэн гүний, нэн түгээмэл шинжтэй биегүй эсрэг тэсрэг талууд; Нагаржунайн дундат үзлийн онолоор бол эхнийх нь мөнх, хоёр дахь нь мөнх бус; эхнийх нь эс тасрах, эс түрдэх, эс ирэх, эс одох, эс төрөх, хоёр дахь нь тасрах, түрдэх, ирэх, одох, төрөх гэх мэт.

3. Голоор нь хуваахад үүссэн EE_1E_2DC тал пирамид нь зөрчлийг бий болгогч билиг нь давамгайлсан биетэй тал; түүний эсрэг $EABE_2E_1$ тал пирамид нь зөрчлийг бий болгогч арга нь давамгайлсан биетэй тал. Эхнийн нь нөхөр, хоёр дахь нь эхнэр; эхнийх нь үр хүүхэд, хоёр дахь нь эцэг эх; эхнийх нь удамшил, хоёр дахь нь хувьсал; эхнийх нь төрийн тэргүүн, хоёр дахь нь ард олон; эхнийх нь багш, хоёр дахь нь шавь; эхнийх нь атомын цөм, хоёр дахь нь атомын электрон гэх мэт.

4. ABCD суурь дахь ($\leftarrow$) сумаар билгийн шинж аргын талд, ($\rightarrow$) сумаар түүний эсрэг аргын шинж билгийн талд шингэнэ. Энэ нь дээд талын ($\leftarrow$) сумаар нөхрийн шинж эхнэрт, эцэг эхийн шинж үр хүүхдэд; удамшлын шинж хувьсалд, доод талын сумаар ($\rightarrow$) дээрхийн яг эсрэг шингэлт явагдана гэсэн үг.

5. Пирамидын орой руу өгсөх сумаар ($\nwarrow$) арга, билиг хоёрын шинж нэг нь нөгөөдөөн шингэн шүтэн барилдахдаа спирал буюу улиран дэвших мандах замаар нэгдэл, улмаар дээд нэгдэлд, хөгжил хөдөлгөөний оргил шатанд хэрхэн хүрч очихыг; уруудах сумаар ($\swarrow$) арга, билиг хоёрын бие биендээ шингэн шүтэн барилдсан шинж хэрхэн задран, бутарч тухайн тогтолцоо эвдрэхийг тус тус харуулна.

Квадратын хууль хийгээд арга, билгийн тэмдэг Хэрэв пирамидыг оройн талаас нь хавтгай дээр проекцлон буулгаваас пирамидын хууль квадратын хууль болон буулгагдана; өөрөөр хэлбэл эхнийхийг нь (пирамидын хуулийг) хоёр дахиар (квадратын хуулиар) төлөөлүүлж тайлбарлаж болно гэсэн үг. Ингэх нь пирамидын хуулийг ойлгож, уг хуулиар арга зүй хийн аливааг тайлбарлахад тохиромжтой, хялбар дөхөм болгоно. (Зураг №2)




Зураг №2

Квадрат нь арга, билгийн тэнцвэрт хийгээд тэнцвэрт бус тогтолцооны шүтэн барилдлагыг илэрхийлнэ; ADC, ACB тэгш өнцөгт нь аливаа юмс, мөн чанарын биегүй арга, билгийн тэнцвэрт тогтолцоо буюу симметри, E_1E_2DC нь 75%-ийн билиг, 25%-ийн арга; E_1E_2AB нь болохоор арга нь 75%, билиг нь 25%; тэдгээр нь тус тусдаан бол тэнцвэрт бус тогтолцоо асимметри; Асимметри; 180° эсрэг тэсрэг; талууд өөр хоорондоо шүтэн барилдаж тэнцвэрт тогтолцоо, симметрийг бий болгоно. Эхнэрт арга, билгийн харьцаа 3:1; нөхөрт 1:3; үр хүүхэд мөнхүү харьцаа

3:1, эцэг эхэд 1:3, ард олонд арга, билгийн харьцаа 3:1, төрийн тэргүүнд 1:3 гэх мэтээр байна. Энэ утгаараа тэд тус тусдаа бол тэнцвэрт бус тогтолцоо; харин тэдний шинж бие биедээн шингэн нийлэн нэгдэхээр тэнцвэрт тогтолцоог (ADCB) бий болгоно. Квадрат дахь дээд талын сумаар ($\leftarrow$) билгийн шинж аргад, нөхрийн шинж эхнэрт шингэнэ. Шингээлтийн геометрийн утга гэвэл E_2EA гурвалжингийн талбай ихсэж, ABE_1E дөрвөн өнцөгтийн талбай багасна; гэхдээн эхнэр нөхрийн шинжийг хичнээн ч ихээр шингээлээ гэхэд арга нь буюу сэтгэл нь давамгайлсан тэнцвэрт бус тогтолцоо хэвээр байх ёстой болохоор тэрхүү шүтэн барилдлага, шингээлт "эхнэр" талын 2-оос 3-т байхаар төсөөлөгдөнө. 4 нь. ялангуяа 5 нь арга билиг болчихсон, нөхрийн шинжийг

хэтрүүлэн шингээж, үзэл бодол, сэтгэл санаа, үйл ажлын хувьд нөхөр шиг, эр хүн шиг болчихсон, эхнэр гэсэн үг. 5-ийн төгсгөлийг аргын билигт шингэн ууссан уусалтын туйлшрал гэдэг. 1-ийн төгсгөл нь аргын салалтын туйлшрал. Квадрат дахь доод талын сумаар ($\longrightarrow$) аргын шинж билигт, эхнэрийн шинж нөхөрт шингэн шүтэн барилдана; Шингээлтийн хувилбарууд нь дээрхийн яг эсрэг.


Зурагт дүрсэлсэн квадратаар бол арга, билгийн шингэлт, шүтэн барилдлага нь нар буруу эргэлтээр дотогшоо хумигдах спиралаар явагдана; эргэлт олон дахин давтагдсаар квадратын голын E цэгт очно; энэ бол пирамидын орой, аргыг дээд зэргээр шингээсэн билиг; сэтгэлийг дээд зэргээр шингээсэн буюу ухаан, мөнх бусыг дээд зэргээр шингээсэн мөнх; тасархайг дээд зэргээр шингээсэн эс тасрах; энэ бол Гегелийн гүн ухаанаар бол туйлын санаа, нагаржунайн дундат үзлийн онолоор бол хоосон чанар, би-г дээд зэргээр шингээсэн би бус; буддын гүн ухааны гэгээрлийн онолоор бол нирван, бурхан. Хэрэв математикийн холбогдох томъёоны дагуу квадратыг тойрог



Зураг №3

болговоос квадратын диагал болон түүний голоор таслан хуваагч шулуун шугамууд нь бас шүтэлцэн, тойргийг таллан хуваагч муруй шугам болон хувирна. Гурвалжингуудын бисектрисүүдийн огтлолцох цэг нь түүний хүндийн төв, буюу загасны нүд болох аж. (Зураг №3) арга билгийн зургийн тэмдгийг (зургийн б) хоёр загасны нүдийг холбон шулуун шугам татахад арга, билиг хоёр 75%:25% харьцаатайгаар хуваагдана. Ийнхүү соёмбо үсгийн голд

байрлах арга, билиг; "хоёр загас" нь угтаан пирамид, бүүр тодруулбаас тухайн тэр пирамидын суурь аж. Зураг№3 дахь арга, билгийн тэмдэг нь соёмбо үсгийн голд байрлах тэмдэг хараахан биш; түүний 7-8 хувилбарын нэг болно. Арга, билгийн тэмдгүүд олон хувилбарууд байх агаад, тэдгээрийн утга агуулгыг кубын хуулиар тайлбарлана.




Зураг№4


Кубын хууль хийгээд арга, билгийн тэмдэг Куб нь оройгоороо нийлсэн зургаан пирамидаас бүтнэ. (Зураг№4) Үүнд:

1. Нүүр талын EBCDA
2. Дээд талын EBB₁CC₁
3. Ар талын EA₁B₁C₁D₁
4. Суурь талын EAA₁D₁D
5. Зүүн гар талын EAA₁BB₁
6. Баруун гар талын ECC₁D₁D

Зураг№2,3 дахь квадрат бол кубын нүүр талын пирамид буюу EABCD. Кубыг талуудаар буюу пирамидын сууриудаар нь задалваас дараах бүтэц бий болно. (Зураг№5 а,б)




(a)



(б)

Зураг№5


Арга, билгийн пирамид, тэмдгүүд хоёр нь хоёроороо 180° эсрэг, өөр хоорондоо шүтэн барилдана. Кубын суурь пирамид буюу (4) нь арга нь билгээсээ давамгайлсан нар зөв эргэлттэй (зургийн а-гийн 4) байхад түүний эсрэг кубын нүүр тал буюу (1)-нь (зургийн а-гийн 2) билиг нь аргаасаа давамгайлсан нар буруу эргэлттэй; кубын ар тал болох пирамид буюу (3) нь билиг нь аргаасаа давамгайлсан нар зөв эргэлттэй байхад түүний дээд тал "таг" болох пирамид (2) нь дээрхийн эсрэг арга нь билгээсээ давамгайлсан нар буруу эргэлттэй; кубын баруун гар тал болох пирамид буюу (5) нь билиг нь аргаасаа давамгайлсан нар зөв эргэлттэй хэвтээ огтлолтой байхад, түүний зүүн гар талын пирамид буюу (6) нь түүний яг эсрэг арга нь билгээсээ давамгайлсан нар буруу эргэлттэй байх жишээтэй. Квадрат дахь сум, арга билгийн тэмдгийн давамгайлсан талын эргэлтийн зүг чигийг заана. Тэгээд (4), (1) хоёр шүтэн барилдаж (5)-ийг; (2), (3) хоёр шүтэн барилдаж (6)-г; (5), (6) хоёр шүтэн барилдаж (7)-г бий болгоно. (Зураг №6)



Зураг №6

Арга билгийн шүтэн барилдлагын дээд оргил бол билиг нь аргаасаа давамгайлсан нар буруу эргэлттэй арга, билгийн тэмдэг (7) эсвэл арга нь билгээсээ давамгайлсан, нар зөв эргэлттэй арга, билгийн тэмдэг (8) аж. Энэ бол атомын цөмийн доторхи эгэл жижиг хэсэг болох соронзон цахилгаан орны долгион, бөмбөлөг хоёрын шүтэн барилдлага ч юм уу; буддын гүн ухааны хоосны дээд хоосон чанар, тарнийн ид шидийг олсон хүн, нирван чиг юмуу,


хятадын Инь, Ян-ийн гүн ухаанд (7), (8)-г Тай Цзу буюу дээд нэгдэл хязгаар, оросоор великий предел¹ гэнэ. (Зураг№7).




Зураг№7

Дээд нэгдэл буюу Тай Цзи-гийн задаргааг янз бүрийн аргаар тэмдэглэж болох агаад хятад, солонгос, японд арга билгийн харьцаа 1:3 хэмээгээд шулуун хийгээд тасархай зураасын хослолоор уг задаргааг хийж ирсэн уламжлалтай. Тэдгээр нь тэнцвэрт хийгээд тэнцвэрт бус, симметри хийгээд асимметрийн шүтэн барилдлагын зүй тогтлоор холбогддог аж. Хятадын гүн ухаанд биегүй аргыг “Ян” (зураг№2-т бол ABC), биегүй билгийг “Инь” (зураг№2-д бол ADC), арга нь давамгайлсан биет аргын талыг “Тай янь, шао янь”; билиг нь давамгайлсан биет билиг талыг “тай инь, шао инь” гэнэ. Зураг№2 дээр бол эхнэрт арга, билгийн харьцаа 3:1 (зураг№7-дээр бол шулуун зураас гурав $\equiv$ тасархай зураас нэг $-$), нөхөрт арга, билгийн харьцаа 1:3 Янь, Инь-ээр бол шулуун зураас нэг $-$, тасархай зураас гурав $\equiv$. Зураг№7-д дүрсэлсэн триграм бол кубыг бүрдүүлэгч зургаан пирамидын зөвхөн нэг нь. Хэрэв зургаан пирамидыг нэг хавтгай дээр проекцлон буулгаваас зургаан хушуу буюу тетраэдр үүснэ. (Зураг№8а,б)

¹ М.И.Беляев. Милология. 1999-2001, Вебсайт. www.yandex.ru. Belyaev m. I. Гармония Ян и инь. 155 дахь тал




(a)



(б): (сум нь хос шад болно)

Зураг№8


триграммыг буюу кубын арга, билгийн тэмдгийн бүтцийг хятадын "Инь", "Ян"-ийн нийтлэг загварт оруулбаас дараах дүрсийг үүсгэнэ. (Зураг№9а)




Зураг№9

Зураг№7 дахь дүрс бол пирамид, учир нь жижиг тойргоор дүрсэлсэн бүхэн нь хоёр хоёроороо бол арга, билиг; арга, билгээс бүтэх квадрат, квадратын задаргаа. Зураг№8 болохоор куб, учир нь гурвалжин буюу арга, билгийн задаргаа. Зураг№8 болохоор куб, учир нь гурвалжин буюу арга, билгийн тэмдэгт бүр пирамид; пирамидын задаргаа; тэрхүү задаргааны шат бүрт арга, билгийн шүтэлцээ 1:3, 3:1 байна. (Зураг№9) Тухайн тэр тэмдэгтийн хувьд ч мөн адил болохоор II үеийн 6,5-ийн, III үеийн 1,2,3,4-ийн талбайн нийлбэр ч

мөн 1:3 гэсэн арга, билгийн тогтолцоотой байна. 1-4-ийн талбайн арга, билгийн задаргааны IV үед ч мөн адил тухайн дүрсийн хувьд (1,8-аас бусад нь), нийт дүрсийн (1-8) талбайн бүтцийн хувьд ч арга, билгийн харьцаа 1:3 байна гэсэн үг. (Зураг№10)




(5-8-ийн нийлбэр тайлбай)
(а)



(1-4-ийн нийлбэр тайлбай)
(б)

Зураг№10

байдаг бололтой; ямар ч байсан IV үеийн бүх тохиолдлыг (1-8), зураг№10, дахь нар, хавирган сар хоёрын хослолоор илэрхийлж болж байна. Кубын хуулийн арга, билгийн утга, тогтолцоог эртний монгол мэргэдүүд ингэж ч тэмдэглэж байсан болов уу. Харин хятадын "Инь", "Ян"-ийн гүн ухаан дахь



Зураг№11

Триграмм буюу кубын задаргааг арга, билгийн тойргоор тэмдэглэх нь утга учрын хувьд төгөлдөр хэдий ч IV үеэс эхлэн бэрхшээлтэй болдог юм байна; учир нь IV үеэс эхлэн сонгодог загвар болох "хоёр загас" өөр дүрсэд хувирах хууль

арга, билгийн задаргааны зураасан тэмдэглэл нь арга, билгийн харьцааг (1:3) зөв тэмдэглэхээс гадна, уг задаргааг хязгааргүй шахуу үргэлжлүүлэх бололцоотой юм байна. Хэрэв зураг№9-ийг төв хүрээний тогтолцоонд оруулбаас (Зураг№11)

Төв I бол пирамидийн орой, хүнээр бол түүний уураг тархи, атомаар бол түүний цөм, нарны системийн гарагаар бол нар, түүхээр бол эзэнт гүрэн гэх мэт;

хүрээ (II-IV) нь хүнээр бол түүний их бие, атомоор бол электронууд, нарны системийн гарагаар бол дэлхий гэх мэт бусад гараг, түүхээр бол эзэнт гүрний бүрэлдэхүүнд багталцах бусаод улсууд. Төв билиг, хүрээ нь арга; төв нь төвөөс татах (билиг), түлхэх (арга); хүрээ нь төврүү тэмүүлэх (билиг), төвөөс зугтах (арга) хүчний үйлчилгээ; Энэ бүхэн өөр хоорондоо шүтэн барилдаж байж төв хүрээний тогтолцоог бий болгоно. Хүрээний элементүүд (II, III, IV) төвд (I) ойртохын хирээр төвийн шинжийг өөртөө илүү ихээр шингээнэ; холдохын хирээр уг шинж багасна. "Инь Ян"-ны ухаанд энэ задаргаа 64-т хүрнэ; Нагаржунай багшийн 8 үгүйсгэлийн төв нь шүтэн барилдаж бий болсон "Би, үгүй" хоёр; тэр нь задарсаар V дахь үедээ 16, VI дахь үедээ 32, улмаар 64 болж задарсау байх учиртай болж таарч байна. Энэ бол ертөнцийн оршин тогтнох хамгийн гүний бөгөөд хамгийн түгээмэл шинж. Соёмбо үсгийн оройн нар сар бол арга билгийн, Инь Ян-ы тогтолцооны захын буюу IV хүрээнд байрлах арга, билгийн тэмдэг бололтой. Нар сар нь төв хүрээний захын хүрээнд байрлах учир, соёмбо үсгийн дунд биш, захад нь, хамгийн дээд талд нь байрладаг юм байна. Нар сарны дээд талд нь түүнээс урган гарсан гал нь (☯) болохоор арга, билиг нь 8-аас 16, 16-аас 32; 32-оос 64 болон задарна, ер нь ертөнц орон зайн хувьд хязгааргүй гэсэн утга санааг загварчлан илэрхийлсэн хэрэг.

Соёмбо үсгийн арга билиг (☯), сум (☰), нар сарны учир ийм ажгуу; сум, арга билиг хоёр нийлээд (☲) билиг нь давамгайлсан арга нь дагасан нар зөв эргэлттэй пирамид аж. Тийм пирамид нь кубын тогтолцоонд ар талын, түүнд хойноос нь орж ирэх пирамид (Зураг№4-ийн $A_1B_1C_1D_1$ -ээр тэмдэглэсэн пирамид). Харин бидний өвөг дээдэс арга, билгийн шүтэн барилдлагыг дээдийн дээд буюу I түвшинг илэрхийлсэн хэвтээ арга, билгийн тэмдэг (☯), түүний дараагийн буурах II түвшнүүд (☲☲) байсаар байхад бүүр III түвшний босоо тэмдгийг (☳) сонгон авсны учир юу юм бол гэдэг асуулт тавигдахаар юм. Соёмбо үсгийн голд, бүүр эхнээсээ бол дээд нэгдэл (великий предел) буюу тай цзи хэмээх нар буруу эргэлттэй тэмдэгийг (☲☲) хэрэглэж байгаад сүүл сүүлрүүгээ өнөөгийн энэ тэмдэг болон өөрчлөгдөн зурагдчихсан чиг биш


байгаа гэсэн бодол төрснийг нуух юун. Ямар ч байсан Жалханз хутагтын төрийн ёслолын хувцасны чимэглэлд байх соёмбод хэвтээ нар зөв эргэлттэй арга, билиг бий. (Зураг№12)¹



Зураг№12

Соёмбо үсгийн нар сарны учрыг дээр өгүүлснээр хоёр янзын нар сар байх нь. Эхнийх нь нар нь билиг-75%, сар нь буюу хавирган сар нь арга-25% (Зураг№10-ийн а); хоёр дахь нь нар нь арга-75%, сар нь буюу хавирган сар нь билиг-25% (Зураг№10-ийн б).

Соёмбо үсэг дахь Чойжүн буюу гипотенуз талаараа дээшээ 90° өнцөг талаараа доошоо харсан хоёр




Зураг№13 (зураг№4 дахь кубын хуваагдал)

гурвалжингийн (∇) ч шинжлэх ухааны агуулгыг арга, билгийн үүднээс тайлбарлах үндэслэл бас байна. Пирамид, кубын хууль нь тэр чигээрээ арга, билгийн утга агуулгатай; түүний арга талыг нэг тал гурвалжин, билгийг нөгөө тал гурвалжин илэрхийлнэ. Энэ нь утгаан голоороо, диагналаараа хуваагдсан кубын талууд аж. Гэхдээ дээд талын тал кубын өнцөг нь дээшээ, суурь нь доошоо харсан байхаар төсөөлөгдөнө.

(Зураг№13) Зураг №6,8-д бол кубын AC шугамаар хуваагдсан талууд буюу $1+4=5$, $2+3=6$, $5+6=7$ гэсэн хоёр хоёроор шүтэн барилдаж бий болсон пирамидуудын хуваагдал. Кубыг бүрдүүлэгч пирамидууд нь мөнхийн хөдөлгөөнд оршин тогтноно; гэхдээ нар зөв, нар буруу эргэлтээр улиран дэвшин өөрчлөгдөнө, хөгжинө. Зураг№ 8,б дээр бол (уг зургийг эргэж харна уу) $5 \rightarrow 1 \rightarrow 2$ нар зөв, $4 \rightarrow 3 \rightarrow 6$ нар буруу, эхнийх нь нар зөв эргэж байхад хоёр дахь нь нар буруу нэгэн зэрэг эргэнэ. Учир нь энэ хоёрын эргэлт бол нэг нь нөгөөдөөн багталцсан давхар эргэлт. Харилцан бие биеэ үгүйсгэхийн

¹ Соёмбын нууц ба синергетик. УБ.2005, 381 дахь тал

хэрээр нөхцөлдүүлнэ. Соёмбо тэмдгийн хос шад нь  кубын бүрэлдэхүүнд багталцах зургаан пирамидуудын эргэлтийн загвар юм байна; зүй нь хос шадыг  гэж дүрслээд зүүн гар талын сумыг нь $5 \rightarrow 1 \rightarrow 2$ буюу нар буруу, баруун гар талынхыг нь $4 \rightarrow 3 \rightarrow 6$ буюу нар зөв эргэлтийг тэмдэглэсэн хэмээн унших ёстой юм байна. Дээр ярьсан бүхнээс соёмбо үсэг нь дараах дүрс хэлбэртэй байхаар (Зураг№14).



Зураг№14

Соёмбо үсэг бол зургаан пирамидын шүтэн барилдлагыг кубын буюу ертөнцийн тогтолцооны хамгийн гүний бөгөөд түгээмэл хуулийн загвар модель. Монгол улсын тусгаар тогтнолын бэлгэдэл болсон соёмбо үсэг бол сэтгэлгээний хамгийн зөв, алдаагүй, түгээмэл арга ухаан, эртний байтугай орчин үеийн шинжлэх ухаанд ч түгээмэл арга зүй болохоор утга агуулгатай. Оросын эрдэмтэн М.И.Беляев "Милогия" (1999-2005) хэмээх олон зуун хуудас номонд "Инь Ян"-ын үндсийг тайлбарлаж, түүнийг орчин цагийн нийгмийн, байгалийн бараг бүх шинжлэх ухаанд хэрэглэж,

тухайн тухайн шинжлэх ухааныг судалдаг хууль зүй тогтлыг гайхалтай гүнзгий тайлбарласан байдаг аж¹.

Монголчууд бид соёмбо тэмдгээ шүтэн дээдлэж орой дээрээ залахын учир гэвэл ертөнцийн оршин тогтнох хамгийн гүний бөгөөд түгээмэл хуулийн тухай сургаал номыг ухааран ойлгож, түүний шүтэн гэгээрэхийн; зөв бодож бий болгосон зөв санаа бодлоор зөв үйлийг бүтээж залуу үеэ хүмүүжүүлж, улс эх орноо хамгаалан хөгжүүлж, үндэстний тусгаар тогтнолоо үүрд мөнх авч явна гэсэн үг аж. Соёмбо үсэг нь ертөнцийн үзэгдэл юмсын оршин тогтнох хамгийн гүний, хамгийн түгээмэл, гэгдэх кубын хуулийн агуулгыг евклидийн геометрт байх хэдхэн дүрсээр хураангуйлан загварчлан яруу сайхан илэрхийлдэгээс хөөж бодоход Занабазар өндөр гэгээнтэн өөрөө гарамгай суут төдийгүй дээд оюунтай хүн байжээ гэж бодогдоно.

¹ М.И.Беляев. Милогия. 1999-2001, Вебсайт. www.yandex.ru. Belyaev м. I. Гармония Ян и инь. 155 дахь тал

Дэлхийн улс үндэстнүүд ертөнцийн үзэгдэл юмсын хөгжил хөдөлгөөний уг сурвалж болох зөрчлийн эсрэг талууд шүтэн барилдах тэр хамгийн гүний бөгөөд түгээмэл зүй тогтлын дараах загвар моделийг, улс үндэстнийхээ тусгаар тогтнол, өөрсдийн үзэл онол сургаал зэргийн үүрд мөнх байхын бэлгэдэл болгон хэрэглэж, түүнийгээ шүтэн дээдэлсээр ирсэн үүх түүхтэй.


Үүнд:



1. Таван хошуу. Ертөнцийн тогтолцооны зөв бөгөөд бэх бат загвар модель. Энэ нь ертөнцийн тогтолцооны тухай 5 махбодын онолын агуулгын загвар модель гэсэн үг. 5 хошуу нь угтаан кубын 1,2,3,4, дахь пирамид; тодруулваас 1,4 хоёрын, 2,3 хоёрын шүтэн барилдлага, шүтэн барилдаж бий болсон хоёр пирамидуудын (5,6) мөн шүтэн барилдлага, дээд нэгдэл 7 юм. (Зураг№5-6) Энэ тохиолдолд дээд нэгдэл буюу 7 нь таван хошууны оройд (3-т), бусад нь 180° эсрэг чанараар таван хошууны үлдсэн 4 хошуунд байрлана. Америк, Вьетнам, Хойд солонгос, Хятад зэрэг өөр бусад улсын төрийн далбаанд байрладаг тэмдэг.



2. Хас тэмдгийн буюу кубын хуулийн нэгэн хувилбар; Дөрвөн тал нь кубын 4 тал, голынх нь тэдгээр талын шүтэн барилдлага. (Зураг№6-ийн бол 1,4; 2,3; 7,8) Европын нэлээд улс орны одон, христос шашны загалмай, нацист германы төрийн бэлгэдэл, гавъяаны одон гэх мэт болдог.



3. Арга билиг. Кубыг бий болгогч 6 пирамидын шүтэлцээний дээд түвшин. Арга, билиг; Ян инь; Өмнөд солонгосын төрийн бэлгэдэл. соёмбо тэмдгийн голд байвал байхаар тэмдэг.



4. Хас тэмдэг. Кубыг бий болгогч 6 пирамидын буюу арга, билгийн шүтэлцээний дээд түвшин, нэгдлийн загвар. Хас тэмдгийг эрт дээр үеэс бат бэхийн зөв шүтэлцээ, тогтолцооны бэлгэдэл болгон хэрэглэсээр ирсэн улс үндэстнүүд бий. Хэвтээ, босоо гэсэн хоёр бүлэг хас тэмдэг бий. (Зураг№15)



5. Зургаан хошуу. Арга, билиг; кубыг бүрдүүлэгч 6 пирамидын гурав нь хамтдаа нар зөв, гурав нь түүний эсрэг нар буруу эргэлттэй тогтолцоог илэрхийлнэ. (Зураг№86) Еврэй угсаатны үндэстний бэлгэдэл тэмдэг.



6. Соёмбо тэмдэг. Ертанцийн тогтолцооны түгээмэл хууль болох кубын хуулийн загвар модель; Монгол үндэстний тусгаар тогтнол, эв нэгдлийн бэлгэдэл.

Энд зураглан харуулсан бүх тэмдэгтүүдээс куб, түүний бүрэлдэхүүн хэсгүүд, кубын хуулийг илүү бүрэн, тодорхой харуулдаг, илэрхийлдэг нь соёмбо тэмдэг юм байна. Соёмбо үсгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, шинжлэх ухааны утга талаас нь дараахь үг, өгүүлбэрээр нэрлэж, томъёолж болохоор байна. Үүнд:



1. Чойжүн. Билиг тал нь давамгайлсан тал куб; өөрөөр хэлбэл билиг талын тал куб (Зураг№13-ийн $EAA_1C_1CDD_1$) энэхүү тал нь EAA_1DD_1 , EDD_1C_1C гэсэн бүтэн пирамид; $EADC$, $EA_1D_1C_1$ гэсэн тал пирамидаас бүтнэ.



2. Чойжүн. Арга тал нь давамгайлсан тал куб; өөрөөр хэлбэл арга талын тал куб. (Зураг№13-ийн $EAA_1BB_1CC_1$) энэ нь EAA_1BB_1 , ECC_1BB_1 гэсэн бүтэн; $EABC$, $EA_1B_1C_1$ гэсэн тал пирамидаас бүтнэ.



3. Арга билиг. Кубын яг гол дахь арга, билиг (хоёр загас) буюу кубыг бүрдүүлэгч 6 пирамидын нэгдсэн орой; арга, билгийн шүтэн барилдлагын дээд нэгдэл. (Зураг№6-ийн7), (Зураг№7-ийн дээд нэгдэл). Аливаагийн арга, билгийн харьцаа амьдрал дээр бол 75:25 байдаг. (Зураг№3). Хар загас нь билиг, цагаан нь арга.



4. Сум. Шүтэн барилдлагын дээд нэгдэл болох хэвтээ байрлалтай арга билигт нар буруу эргэлт давамгайлж нар буруу эргэлт дагалдана гэдгийг илэрхийлнэ. Ер нь арга, билиг хоёр 180о эсрэг тэсрэг шинжтэй, тухайн тогтолцоонд гүйцэтгэх үүрэгтэй. (Зураг№9-ийн7)



5. Хавирган сар, нар хоёр буюу арга билгийн задаргааны IV үе. Нар, хавирган сар хоёр нь 75:25 харьцаатай байна. Нар нь билиг, сар нь арга. (Зураг№9,10,11)

6. Гал. Ертөнцийн юмс эцэс төгсгөлгүй задаргаатай, өрнийн гүн ухааны хэлээр бол матери нь орон зайн хувьд хязгааргүйг, буддын гүн ухааны хэлээр бол юмс эцэс төгсгөлгүй тасархайг илэрхийлнэ. (Зураг№9,11)



7. Хос шад. Ертөнцийн оршин тогтнох түгээмэл хуулийн загвар болох кубын арга, билиг гэсэн хоёр талын эхнийх нь нар буруу, хоёр дахь нь нар зөв эргэлдэн (Зураг№8-ийн 6, 13) өөр хоорондоо шүтэн барилдахыг илэрхийлнэ.

Хас тэмдгийн тухай товч Соёмбо үсэг дотор хас тэмдгийн зурлага хэдийгээр байхгүй чиг гэсэн түүний голд байрлах хэвтээ арга, билиг нь өөрөө хас төдийгүй наад зах нь зургаан хас тэмдгийн шүтэн барилдлага. Үүнийг хүснэгтээр харуулбал:

арга, билгийн тэмдгүүд буюу кубын талууд (пирамидууд)							
хас тэмдгүүд							

Зураг№15

Соёмбо үсгийн тэмдгийн талаар өдий төдий тайлбар байх агаад мөхөс миний энэ тайлбар нь тэдгээрийн нэгэн хувилбар төдийхөн зүйл; ялгаа нь гэвэл соёмбо тэмдгийн шинжлэх ухааны утга агуулгыг гарган тавихыг оролдсонд бий.

Соёмбын дээр өгүүлсэн тайлбарыг төрийн далбаан дээрх соёмботой харьцуулахад дараах ялгаа харагдана. Үүнд: 1. арга, билгийн ялгарах өнгөөрөө, 2. хамтдаа байрлах нар сар хоёроороо, 3. дээд талын чойжүний (гурвалжны) өнцөг нь өөдөө харснаараа, 4. нар буруу эргэлттэй хэвтээ арга, билгээрээ, 5. хос шад, сумаараа. Тайлбарт шад сум нь шовхдуу үзүүртэй байгаа. Төрийн бэлгэдэлийг уран сайхан зохиомж оролцуулан бүтээх шаардлагаар нар, сар хоёрыг салгасан; хос шад, сумны үзүүрийг тэгшилсэн

байж болох талтай. Харин Чойжүн буюу гурвалжингийн өнцөг нь дээшээ харсныг, арга билгийн "загас" нь нар буруу эргэлттэй хэвтээ байх зэргийг сайтар эргэцүүлэн бодвол зохилтой. Мөхөс миний бие соёмбын тайлбарыг дээрх маягаар хийхдээ монгол улсын төрийн далбаан дээрх, монголчууд бидний өвөг дээдэс шүтэн дээдэлсээр ирсэн соёмбо тэмдэгтэд засвар хийх шаардлага байна гэдгийг үндэслэн гаргахыг огт зориогүй. Учир нь тийм засвар хийх шаардлагагүй; тэгээд ч шүтдэг дээдэлдэг зүйлдээ хамаа намаагүй гар хүрээд түүнийг өөрчлөн хувиргаад байваас түүнд олон түмний итгэх итгэл алдарна, түүнийг шүтэн дээдлэх сэтгэл буурна; соёмбо үсгийн хувьд мөн адил. Дээрх тайлбарыг хийхдээ соёмбо нь ертөнцийн оршин тогтнох, өөрчлөгдөн хувирах, хөгжин дэвших, хамгийн гүний, хамгийн түгээмэл объектив хуулийн болон зөв сэтгэлгээ, шинжлэх ухааны арга зүйн загвар модель юм байна гэдгийг тайлбарлахыг зорьсон болно. Энд өгүүлсэн бүхэн өнөөгийн төрийн далбаан дээрх соёмбын нэмэлт тайлбараас үл хэтэрнэ.

Бурхан багшийн номын хур арвин бууж, монгол хүн бүр
ухаарал, гэгээрлийн оргилд хүрэх болтугай.

Научный смысл государственной эмблемы монголов "соёмбо"

Резюме

Соёмбо как государственная эмблема является не только символом национальной независимости и единства монгольской нации, но и геометрической моделью всеобщего закона существования мира так называемого "закона куба". Суть настоящего закона состоит в том, что источником развития и движения мира служит противоречие между такими противоположностями как Инь и Ян, упая и преджни, управляющей (билиг) и стимулирующей (арга) силой; что как каждый из 6 пирамид куба так сам куб представляет собой единство и борьбу инь и ян, управляющей и

стимулирующей силой и т.п.; что единство осуществляется через борьбу путем спиралообразного движения. Соёмбо как закон куба может служить, в сферах познавательной деятельности человека, самым правильным способом мышления и научной методологией.

Ашигласан ном зохиол

1. Ц.Дамдинсүрэн. "Соёмбо үсэг". Соёмбын нууц ба синергетик УБ, 2005.
2. Б.Ринчен. "Соёмбо тэмдэг бол Монголын эрх чөлөө тусгаар тогтнолын алдарт сайхан бэлгэ тэмдэг". Мөн номонд
3. Б.Болдсайхан. Соёмбын агуулгыг орчин үеийн шинжлэх ухааны үзэл онолтой холбох нь, мөн номонд
4. М.И.Беляев. Милогия. 1999-2001, Вебсайт. www.yandex.ru. Belyaev м. I. Гармония Ян и инь.